

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН
2025 оны 12 дугаар сарын 04
ATA14401 9025010818 5890683

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дугаар 11

2025 оны 12 дугаар сарын 04

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 15:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/641 тоот тушаалын дагуу байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах, үлдэгдэл өртөггүй болсон ч цаашид ашиглах боломжтой эд хөрөнгийг дахин үнэлсэн жагсаалтын дагуу байгууллагын дансанд шинэчлэн бүртгэх тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Дугаар 11

2025 оны 12 дугаар сарын 04

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 15:30 цагт эхэлж 16:00 цагт дуусгав.

Хуралд:

Дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	О.Чулуун-Эрдэнэ
Гишүүд	Г.Ганцэцэг
	Б.Түмэнжаргал
	Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/641 тоот тушаалын дагуу байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах, үлдэгдэл өртөггүй болсон ч цаашид ашиглах боломжтой эд хөрөнгийг дахин үнэлсэн жагсаалтын дагуу байгууллагын дансанд шинэчлэн бүртгэх тухай

СОНССОН НЬ: 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 09 дүгээр хурлаар хэлэлцсэн ашигласан жил дуусаж үлдэх өртөггүй болсон боловч ашиглаж байгаа хөрөнгийг дахин үнэлэх, эвдрэл гэмтэлтэй ашиглах боломжгүй эд хөрөнгийг данснаас хасах саналыг боловсруулан Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсний дагуу тус газрын дарга хөрөнгө актлах А/641 тоот тушаал ирүүлснийг уншиж танилцуулав. Мөн Нийслэлийн өмчийн харилцааны газрын дэргэдэх “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны хөрөнгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон 165,130,500.00 /нэг зуун жаран таван сая нэг зуун гучин мянга таван зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг дахин үнэлж, бүртгэлд тусгах үнийг шинэчлэн тогтоосныг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд танилцууллаа.

Н.Пүрэвсүрэн: Манай зөвлөлийн 09 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай, үлдэгдэл өртөггүй болсон ч ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсний дагуу актлах хөрөнгийн жагсаалт болон дахин үнэлсэн хөрөнгийн жагсаалт гарсан байна. Бидний саналын дагуу нийт 9 нэр төрлийн 6,478,700.00 /зургаан сая дөрвөн зуун далан найман мянга долоон зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж данснаас хасах, 56 нэр төрлийн эд хөрөнгийг дахин үнэлж 165,130,500.00 /нэг зуун жаран таван сая нэг зуун гучин мянга таван зуу/ төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Эдгээр жагсаалттай сайтар танилцаж өөрсдийн саналаа хэлнэ үү.

О.Чулуун-Эрдэнэ: Жагсаалтыг үзэж танилцахад бидний хүргүүлсэн саналын дагуу шийдсэн байна. Иймээс надад өөр санал байхгүй ээ. Хүлээн зөвшөөрч байна.

Б.Түмэнжаргал: Тийм ээ. Манай зөвлөлийн хурлаар шийдсэн жагсаалтын дагуу шийдвэр гарсан байгаа учраас нэмэлт саналгүй байна.

Б.Болортуяа: Саналгүй ээ. Жагсаалтыг үзэж танилцсан.

Н.Пүрэвсүрэн: Гишүүд бүгд нэмэлт саналгүй бол Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирүүлсэн хөрөнгө актлах тушаал, хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох албан бичгийн дагуу бүртгэлд тусгаж ажиллая.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирүүлсэн А/641 тоот Эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай тушаал, 1/2216 тоот Хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоох тухай албан бичгийг үндэслэн холбогдох өөрчлөлтийг хийхийг Нягтлан бодогч Г.Ганцэцэгт,
- Актлах эд хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг, шинэчлэн тогтоогдсон эд хөрөнгийг Өмчийн бүртгэлийн системд холбогдох журмын дагуу бүртгэж, цаашдын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
Дарга
Нарийн бичгийн дарга



Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/
О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/